



“БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХХVII ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020.04.30

Дугаар..01

Улаанбаатар хот

Хаана: “Баянгол Ресторан”-ны Хурлын заал

Хэзээ: 2020.04.30 ны 15 цаг

Хурлын дарга Б.Аюуш: Өнөөдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдах байсан боловч “Улсын Онцгой Комисс”-оос онцгой нөхцөл байдал зарласантай холбоотойгоор хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулахгүйгээр цахимаар болон компанийн байран дээр биечлэн ирж хурлын материалтай танилцаж, санал хураалтыг явуулахаар шийдвэрлэсэн.

Үүний дагуу цахимаар болон биечлэн ирж санал өгөх тухай зарыг 2020 оны 3 дугаар сарын 23, 04 сарын 10 ны өдрүүдэд Монголын мэдээ, Зууны мэдээ сонингуудад хэвлүүлэх, С1 Телевизээр дээрх 2 өдөр тус бүр 10 удаагийн давтамжтайгаар нэвтрүүлж мөн компанийн цахим хаяг, “Монголын Хөрөнгийн Бирж”-ийн цахим хуудсанд хурлын материал болон зарыг байршуулж хувьцаа эзэмшигчдэд мэдээлсэн.

Хурлын бүх материалыг компанийн цахим хуудас, Хөрөнгийн биржийн хуудсанд байршуулахаас гадна тооллогын комиссын гишүүд тусгай хуваариар ажлын өдөр бүр компани дээрээ ажиллан биеэр хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдэд хурлын материалыг танилцуулж, саналын хуудсыг бөглүүлэн лац бүхий битүүмжилсэн хайрцагаар санал авах ажлыг зохион байгуулсан.

Одоо тооллогын комисс ирцийн дүнг танилцуулна. Тооллогын комиссын дарга Т.Бичигмаа эрүүл мэндийн шалтгаанаар чөлөөтэй байгаа тул тооллогын комиссын гишүүн Д.Самданжамцыг комиссын даргаар орлон ажиллахыг зөвшөөрч байна.

Тооллогын комисс “Саналын хуудас”-ын бүртгэлээр саналын ирц бүрдсэн эсэх тогтоолыг танилцуулна уу.

Д.Самданжамц: Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдын бүртгэл гаргасан “Бүртгэх өдөр” – болох 2020 оны 4 дүгээр сарын 9-ний өдрөөс хойш ажлын өдрүүдээр тооллогын комиссийн гишүүд компани дээр ажиллан ирсэн хувьцаа эзэмшигчдэд хурлын материал танилцуулан, саналын хуудас бөглүүлэх ажлыг зохион байгуулсан.

Энэ хугацаанд нийт 54 хувьцаа эзэмшигч “Саналын хуудас” бөглөсөн бөгөөд эдгээр нь нийт 306,895 ширхэг хувьцаа эзэмшиж байгаа нь нийт саналын эрхтэй хувьцааны 80.5 хувь болж байна гээд тооллогын комиссын 1 дүгээр тогтоолыг уншиж танилцуулав./тогтоолыг хавсаргав/

Б. Аюуш: Тооллогын комисс ТУЗ ын гишүүдийн хяналт дор санал хураах хайрцагын лацыг шалган задалж, санал тоолох ажилдаа орно уу. Камерын бичлэгээр баталгаажуулж байна.

За санал тооллого явагдаж байх хооронд Bayangolhotel.mn цахим хаягаар 2 Хувьцаа эзэмшигчээс цахимаар ирүүлсэн асуултуудад хариулт өгсөн талаар тодруулж хэлье.

Хувьцаа эзэмшигч Дэлгэрмаа:

Асуулт 1 : Компани бэлэн мөнгөний үлдэгдэл ихтэй байгаа шалтгаан, түүний өгөөж бондын өгөөжтэй харьцуулахад хир байгаа талаар асуув

Хариулт: Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд дараах тайлбарыг өгч байна

Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн чөлөөт үлдэгдлийг банкуудын эрсдлийг тооцон зохих хэсгийг хүүтэйгээр хадгаламжинд байршуулсан
- Тус компаний орлогын эх үүсвэр нь аялал жуучлалын орлого байдаг бөгөөд тайлант оны эцсээр орлого мөнгөн хэлбэрээр орж ирдэг нь жилийн эцсийн тайлагнах хугацаатай давхцдаг. Мөн оны эхний хагас жилд дараа жилийн бэлтгэл ажил хөрөнгө оруулалт, засвар тохижуулалт, бараа татан авалт хийгддэг учраас оны эцэст мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өндөр дүнтэй байдаг боловч 1,2 –р улиралд ихэнх нь зарцуулагддаг болно.

Асуулт 2: Дансны авлагын хэмжээ салбарын дунджаас өндөр байгаа шалтгаан ? Хаанас авлагатай вэ?

Хариулт: Авлагын дийлэнх хэсэг нь Женко тур бюро ХК аас авах авлага бөгөөд анх компани үүсгэн байгуулах үед “Их эзэн Чингис” хааны морьт хөшөөг барьж байгуулахтай холбоотой их зардлыг манай компани санхүүжүүлж байсантай холбогдон үүссэн авлага бөгөөд одоо түүний зарим хэсэг нь төлөгдөөгүй байгаа болно.

ТУЗ энэ авлагыг барагдуулах асуудлыг тусгайлан хэлэлцэж, 2020 онд энэ авлагыг барагдуулах талаар тууштай арга хэмжээ авах болно. Ийм учраас ирэх жилд авлага ихээхэн багассан байх болно.

Хувьцаа эзэмшигч Б.Жүгдэррагчаа

Асуулт 1 : Компани бэлэн мөнгөний үлдэгдэл өндөр байгаа шалтгаан, түүний өгөөж бондын өгөөжтэй харьцуулах

Асуулт 2: Дансны авлагын хэмжээ салбарын дунджаас өндөр байгаа шалтгаан ? Хаанас авлагатай вэ?

Асуулт 3 : Хувьцааны ногдол ашгийн өгөөжийг хувиар илэрхийлж байна уу?

Дээрх 2 асуулт давхардсан тул 3 дахь асуултанд хариулъя: Манай компани энэ жил нэгж хувьцаанд 360 төгрөгийн ногдол ашиг хуваарилж, 2020 оны 9 дүгээр сарын 01-ээс компани дээрээ олгож эхлэхээр ТУЗ шийдвэрлэсэн. Ер нь Монголын Хөрөнгийн биржийн

бүртгэлтэй Хувьцаат компаниудаас жил бүр 20 гаруйхан компани л ногдол ашиг хуваарилдаг. Манай компани нь жил бүр ногдол ашиг хуваарилаж ирсэн бөгөөд ногдол ашгийн хэмжээгээр эхний 5-д байнга орж байгаа гэдгийг мэдэгдэх нь зүйтэй гэж бодож байна. Зочид буудлын зах зээл дээр өрсөлдөөн ихтэй байгаа өнөө үед өрсөлдөх чадвараа хадгалахын тулд их хэмжээний хөрөнгө оруулалт, засвар тохижилт шаардлагатай болж байна. Тийм учраас дотоод өөрийн эх үүсвэрээр хөрөнгө оруулалт хийх шаардлагатай байна. Өндөр ногдол ашиг хувиарлах боломж хязгаарлагдмал байгааг харгалзан шийдвэр гаргасан.

Б.Аюуш: Тооллогын комисс ажлаа дууссан уу? Дууссан бол тогтоолоо танилцуулна уу

Д.Самданжамц: Тооллогын комиссын 2 дугаар тогтоолыг уншиж танилцуулав. /тогтоол хавсаргав/

Б.Аюуш: Тооллогын дүнг үндэслэн хэлэлцэж буй 3 асуудлаар шийдвэр гаргахыг зөвшөөрч байна. Иймд санал хураалтаар 3 асуудал шийдвэрлэгдлээ. Тогтоолын төслүүдийг уншиж танилцуулъя.

ТУЗ-ын нарийн бичгийн дарга Р.Цогзолмаа: Хувьцаа эзэмшигч Уянга, Алтансүх, Эрдэнэчимэг, Намсрайцэрэн нар саналын хуудсаа хайрцаг нээснээс хойш ирүүлсэн тул хүлээн авч хүчингүй хуудсаар тооцох уу?

Б.Аюуш: Тэгье, Хурлын материалтай танилцуулж саналын хуудсыг хүчингүйгээр тооцож бүртгэлд хавсаргая.


Дарга



Б.Аюуш

Протокол хөтөлсөн.

ТУЗ-ын нарийн бичгийн дарга

 Р.Цогзолмаа